



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын бүрдүүлэлт,
зарцуулалт, үр дүн



**ИТХ-ын дэргэдэх хяналтыг хороог байгуулаагүй,
ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлуудад тавих
мэргэжлийн байгууллагын хяналт хангалтгүй, улсын
комисс чанаргүй ажлуудыг хүлээн авсан байна.**

2017 он

<p>Тайланг бэлтгэсэн:</p> <p>Говьсүмбэр аймгийн Аудитын газар</p> <p>Аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа</p> <p>Ахлах аудитор Ц.Батсайхан</p> <p>Аудитор Г.Наранбаяр</p> <p>2017 оны 04 дүгээр сар</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3156, 7054-3179 дугаарын утсаар харилцана уу.</p> <p>Байгууллагын хаяг:</p> <p>ГСА Сүмбэр сум 3-р баг, Нутгийн удирдлагын ордон 2-р давхар б корпус 208 тоот</p>	<p>Товчилсон үгийн тайлбар4</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5</p> <p>Бүлэг 1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон аймгийн ОНХС-гаас олгох шилжүүлгийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу санхүүжүүлээгүй байна.</p> <p>1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн байна.</p> <p>1.2 Аймгийн болон сумдын ОНХС-гийн орлогыг 3 нэр төрлөөр төлөвлөсөн байна.</p> <p>1.3 Сүмбэр сум ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл 2,892.6 мянган төгрөгийг ОНХС-гийн орлогын төлөвлөгөөнд оруулж батлуулаагүй байна.</p> <p>1.4 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон аймгийн ОНХС-гаас олгох шилжүүлгийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу санхүүжүүлээгүй байна.</p> <p>Бүлэг 2. ОНХС-аар хэрэгжүүлсэн ажлуудын гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагаас тавих хяналт хангалтгүй байна.</p> <p>2.1.ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөж, урьдчилсан саналын жагсаалтыг батлуулсан байна.</p> <p>2.2 ОНХС-аас сумдад иргэдийн санал авч эрэмблэгдээгүй зарим ажлуудыг ИТХ-ын тогтоолоор баталж, хэрэгжүүлсэн байна.</p> <p>2.3 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын ТЭЗҮ, зураг төсөв нь урьдчилан батлагдсан байна.</p> <p>2.4 ОНХС-аар хэрэгжүүлсэн зарим хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг хууль журмын дагуу сонгон шалгаруулаагүй байна.</p> <p>2.5 ОНХС-ийн хөрөнгийг сумын удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулсан байна.</p> <p>2.6 ОНХС-аар хэрэгжүүлсэн ажлуудын гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагаас тавих хяналт хангалтгүй байна.</p> <p>2.7 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд бэлтгэсэн зарим хөрөнгийг холбогдох байгууллагуудын данс бүртгэлд бүртгэж, тайлагнаагүй байна.</p>
---	--

Бүлэг. 3 ОНХС-ийн зарцуулалтад тавих шат шатны хяналт хангалтгүй байгаагаас хэрэгжилтийг тайлагнаагүй байна.

3.1 ИТХ-ын дэргэдэх хяналтын хороог байгуулаагүй, аймгийн Дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгээгүй байна.

3.2 ОНХС-гийн хэрэгжилтийн тайланг аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлээгүй байна.

3.3 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн мэдээллийг зааврын дагуу ил тод мэдээлсэн байна.

3.4 Орон нутгийн хөгжлийн сангийн зааврыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

3.5 Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 40 хувьтай байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал

Холбогдох байгууллагаас ирүүлсэн саналд хийсэн тайлбар

ҮАГ-т уламжлах санал

Зөрчлийн нэгтгэл

Судалгаа

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд аудит хийж, аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, цаашид сайжруулах санал зөвлөмж боловсруулан дүнг ҮАГ болон АИТХ, холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын хамрах хүрээ:

Аудитад аймаг, сумдын ИТХ, Засаг дарга, ЗДТГ, СТСХ, Багийн Засаг дарга, ИНХ-ыг хамруулж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, шалгалтын тайланг хамрууллаа.

Үндсэн мэдээлэл:

Монгол Улсын 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж буй “Төсвийн тухай” хуулиар аймаг, нийслэл, сум, дүүрэгт Орон нутгийн хөгжлийн сан байгуулсан нь орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлж, орон нутгийн удирдлагын идэвхи санаачлага, хариуцлагыг сайжруулсны зэрэгцээ төсвийн төлөвлөлт, зарцуулалтад иргэдийн оролцоог буй болгож, орон нутгийн хөгжлийг дэмжих, тулгамдсан асуудлыг иргэдийнхээ санал, санаачилгад тулгуурлан шийдвэрлэх ихээхэн үр дүнтэй ажил болжээ.

2016 онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тус аймагт 2,227.423.1 мянган төгрөгийн орлогын шилжүүлгийг олгохоор төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 100 хувь олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2-т “Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн хөгжлийн санд энэ хуулийн 59.3-т заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна” гэсний дагуу нийт 1,336,453.8 мянган төгрөгийн санхүүжилтээс 610,435.5 мянган төгрөг буюу 45.7 хувийг Сүмбэр суманд, 356,996.2 мянган төгрөг буюу 26.7 хувийг Шивээговь суманд, 369,023.1 мянган төгрөг буюу 27.6 хувийг Баянтал суманд тус тус хуваарилж олгосон байна.


Аймаг, сумдын ОНХС-ийн орлогын эх үүсвэрийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Орлогын нэр төрөл	Аймгийн ОНХС	Сүмбэр сумын ОНХС	Шивээговь сумын ОНХС	Баянтал сумын ОНХС	Нийт дүн
1	ОНХС-ийн шилжүүлгээр	890,969.3	610,434.5	356,996.2	369,023.1	2,227,423.1
2	Өмнөх оны үлдэгдэл	134,850.7		9,000.0	13,493.6	157,344.3
3	Орон нутгийн татварын орлогоос	694,157.8				694,157.8
4	2015 оны Үндсэн тэнцлийн ашгаас	394,093.3	139,521.1	2,937.7	19,869.4	556,421.5
	Нийт дүн	2,114,071.1	749,955.6	368,933.9	402,386.1	3,635,346.7

Хүснэгтээс харахад: ОНХС-гийн эх үүсвэрийг орлогын 4 нэр төрлөөр төлөвлөсөн байна.

Сүмбэр сум ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл 2,892.6 мянган төгрөгийг ОНХС-гийн орлогын төлөвлөгөөнд оруулж батлуулаагүй байна Гүйцэтгэлээр аймаг, сумдууд ОНХС-ийн орлогыг 100 хувь бүрдүүлж ажилласан байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн орлого, зарлагын гүйцэтгэлийг графикаар харуулбал:



Графикаас харахад: Аймгийн ОНХС 524.505.3 мянга, Сүмбэр сумын ОНХС 37.376.0 мянга, Баянтал сумын ОНХС 231,301.9 мянган төгрөгийн ажлуудыг тухайн ондоо багтаан хэрэгжүүлээгүй, он дамжсан үлдэгдэлтэй байна.

Аймаг болон сумдын ОНХС-гийн батлагдсан төсвийн өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/					
Д/д	ОНХС-гийн нэр	Тодотгол хийсэн тоо	Анх батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Зөрүү
1	Аймгийн ОНХС	4	1,381,360.0	2,114,071.1	732,711.1
2	Сүмбэр сумын ОНХС	3	728,557.7	749,955.6	21,397.9
3	Шивээговь сумын ОНХС	2	393,214.3	368,934.0	-24,280.3
4	Баянтал сумын ОНХС	3	406,461.4	402,386.1	-4,075.3
Нийт		12	2,909,593.4	3,635,346.8	725,753.4

Хүснэгтээс харахад: Анх батлагдсан төсвийг аймгийн ОНХС 732,711.1 мянга, Сүмбэр сумын ОНХС 21,397.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь татварын орлого нэмэгдсэн, үндсэн тэнцлийн ашиг төвлөрүүлсэн зэрэгтэй холбоотой байна. Тухайлбал:

Аймгийн ОНХС-д анх 1,381,360.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж 4 удаа төсвийн тодотгол хийхдээ 2015 оны дутуу ажлын санхүүжилт 350,045.1 мянга, шинээр эхлэх хөрөнгө оруулалтын ажлыг 240,039.4 мянга, их засврын ажлыг 345,076.9 мянга, нийт 935,161.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, тоног төхөөрөмжийг 169,317.0 мянга, хөтөлбөр төсөл арга хэмжээг 33,133.3 мянга нийт 202,450.3 мянган төгрөгөөр хасагдуулж, 2,114.071.1 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Сүмбэр сумын ОНХС-д анх 728,557.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж 3 удаа төсвийн тодотгол хийхдээ 2015 оны дутуу ажлын санхүүжилт 329,146.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, шинээр эхлэх хөрөнгө оруулалтын ажлыг 203,223.0 мянга, их засврын ажлыг 61,460.9 мянга, тоног төхөөрөмжийг 30,010.3 мянга, хөтөлбөр төсөл арга хэмжээг 13,054.1 мянга нийт 307,748.3 мянган төгрөгөөр хасагдуулж, 749,955.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Шивээговь сумын ОНХС-д анх 393,214.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж 2 удаа төсвийн тодотгол хийхдээ 2015 оны дутуу ажлын санхүүжилт 156,019.1 мянга, тоног төхөөрөмжийг 7,990.0 мянга, нийт 164,009.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, шинээр эхлэх хөрөнгө оруулалтын ажлыг 58,214.3 мянга, их засврын ажлыг 122,849.4 мянга, хөтөлбөр төсөл арга хэмжээг 7,225.7 мянга нийт 188,289.4 мянган төгрөгөөр хасагдуулж, 368,934.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Баянтал сумын ОНХС-д анх 406,461.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж 3 удаа төсвийн тодотгол хийхдээ 2015 оны дутуу ажлын санхүүжилт 104,504.0 мянга, хөтөлбөр төсөл арга хэмжээг 14,700.1 мянга нийт 119,204.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, шинээр эхлэх хөрөнгө оруулалтын ажлыг 113,279.4 мянга, зөвлөх үйлчилгээний зардлыг 10,000.0 мянга нийт 123,279.4 мянган төгрөгөөр хасагдуулж, 402,386.1 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Бүлэг 1

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон аймгийн ОНХС-гаас олгох шилжүүлгийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу санхүүжүүлээгүй байна.

1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд аймгаас төвлөрөх орлого 465,500.0 мянга, дотоодын НӨАТ-ын 10 хувь 1,581.900.0 мянга, газрын тосны нөөц ашигласны төлбөрөөс 277,700.0 мянга, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хуваарилалтын 5 хувь 93,200.0 мянга, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн орлогын 50 хувь 35,100.0 мянга, нийт 2,453.400.0 мянган төгрөгийн орлогын шилжүүлгийг авахаар, шилжүүлгийн орлогын 60 хувь буюу 1,472,040.0 мянган төгрөгийг сумдад олгохоор батлагдсан аргачлалын дагуу тооцож, Сүмбэр суманд 672.364.4 мянга, Шивээговь суманд 393,214.2 мянга, Баянтал суманд 406,461.4 мянган төгрөгийг тус тус хуваарилахаар төлөвлөсөн байна.

Орлогын бүтцийг диаграммаар харуулбал:



Диаграммаас харахад: Нийт орлогын 65 хувийг дотоодын НӨАТ-ын 10 хувь, 19 хувийг аймгаас төвлөрөх орлого, 11 хувийг газрын тосны НӨАТ, 4 хувийг АМНАТ-ын орлогын хуваарилалт, 1 хувийг АМХ болон АТЗ-ийн орлогын 50 хувиас тус тус төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

1.2 Аймгийн болон сумдын ОНХС-гийн орлогыг 3 нэр төрлөөр төлөвлөсөн байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн эх үүсвэрийг хуульд заасны дагуу орлогын дараах төрлөөр төлөвлөсөн байна. Үүнд:

- 1.ОНХНС-гаас олгох шилжүүлгийн орлого,
- 2.Аймаг, сумдын үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг
- 3.Орон нутгийн татварын орлого гэсэн орлогын 3 нэр, төрлөөр тооцож төлөвлөсөн байна.

1.3. Сүмбэр сум ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл 2,892.6 мянган төгрөгийг ОНХС-гийн орлогын төлөвлөгөөнд оруулж батлуулаагүй байна

Аймаг сумдын ОНХС-гийн эх үүсвэрийг хуульд заасны дагуу ОНХНС-гаас олгох шилжүүлгийн орлого, 2015 оны үндсэн тэнцлийн ашиг, татварын орлогоор бүрдүүлсэн байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн орлогын эх үүсвэрийг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/						
Д/д	Орлогын нэр төрөл	Аймгийн ОНХС	Сүмбэр сумын ОНХС	Шивээговь сумын ОНХС	Баянтал сумын ОНХС	Нийт дүн
1	ОНХНС-ийн шилжүүлгээр	890,969.3	610,434.5	356,996.2	369,023.1	2,227,423.1
2	Өмнөх оны үлдэгдэл	134,850.7		9,000.0	13,493.6	157,344.3
3	Орон нутгийн татварын орлогоос	694,157.8				694,157.8
4	2015 оны Үндсэн тэнцлийн ашгаас	394,093.3	139,521.1	2,937.7	19,869.4	556,421.5
	Нийт дүн	2,114,071.1	749,955.6	368,933.9	402,386.1	3,635,346.7

Хүснэгтээс харахад: Аймаг болон сумдын орлогын эх үүсвэрийн 61.27 хувь буюу 2,227.423.1 мянган төгрөгийг ОНХНС-гийн санхүүжилт, 4.33 хувь буюу 157,344.3 мянган төгрөгийг ОНХС-гийн 2015 оны үлдэгдлээс, 19.09 хувь 694,157.8 мянган төгрөгийг аймгийн татварын орлогоор, 15.31 хувь буюу 556.421.5 мянган төгрөгийг 2015 оны үндсэн тэнцлийн ашгаас тус тус бүрдүүлсэн байна.

Харин Сүмбэр сум ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл 2,892.6 мянган төгрөгийг ОНХС-гийн орлогын төлөвлөгөөнд оруулж батлуулаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2014.03.06-ны өдрийн 43-р тушаалаар баталсан зааврын 8 дугаар зүйлийн 8.7-д “ОНХС-ийн тухайн жилд зарцуулагдаагүй үлдэгдэл болон худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлт нь ОНХС-ийн дансанд үлдэж, дараа жилийн санхүүгийн эх үүсвэртээ тусгагдан ИТХ-аар батлагдан хэрэгжих боломжтой” гэснийг зөрчсөн байна.

Иймд өмнөх оны үлдэгдэл 2,892.6 мянган төгрөгийг 2017 оны төсвийн тодотголоор сумын ОНХС-гийн орлогын эх үүсвэр болгон тодотгож батлуулах албан шаардлага өгөв.

1.4 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон аймгийн ОНХС-гаас олгох шилжүүлгийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу санхүүжүүлээгүй байна.

Тус аймагт ОНХС-гаас 2,453.400.0 мянган төгрөгийн орлогын шилжүүлэг олгохоор төлөвлөсөн боловч улсын төсвийн татварын орлогын төлөвлөгөө дутуу биелсэнтэй холбоотой төсвийн тодотголоор 225,976.9 мянган төгрөгийн орлого хасагдаж, 2,227.423.1 мянган төгрөгийн шилжүүлгийн орлогыг олгохоор төсөв батлагдаж, гүйцэтгэлээр бүрэн санхүүжүүлсэн байна.

2016 онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийн орлогыг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

2016 он	Батлагдсан төсвийн хуваариар олгох шилжүүлгийн дүн	Гүйцэтгэлээр олгосон санхүүжилтийн дүн	Зөрүү
1 дүгээр улирал	338,291.6	230,794.5	107,497.1
2 дугаар улирал	941,254.6	1,052,560.0	-111,305.4
3 дугаар улирал	575,731.4	688,439.3	-112,707.9
4 дүгээр улирал	372,145.5	255,629.3	116,516.2
Нийт	2,227,423.1	2,227,423.1	0.0

Хүснэгтээс харахад: ОНХС-гаас олгох шилжүүлгийг батлагдсан төсвийн хуваариас 2016 оны 1 улиралд 107,497.1 мянга, 4 улиралд 116,516.2 мянга, нийт 224,013.3 мянган төгрөгөөр дутуу, 2-р улиралд 111,305.4 мянга, 3-р улиралд 112,707.9 мянга, нийт 224,013.3 мянган төгрөгөөр тус тус илүү санхүүжүүлсэн байна.

Харин 2016 онд аймгийн ОНХС-гаас сумдад олгосон шилжүүлгийн орлогыг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

2016 он	Сүмбэр сум			Шивээговь сум			Баянтал сум		
	Төсвийн хуваариар	Гүйцэтгэлээр олгосон санхүүжилт	Зөрүү	Төсвийн хуваариар	Гүйцэтгэлээр олгосон санхүүжилт	Зөрүү	Төсвийн хуваариар	Гүйцэтгэлээр олгосон санхүүжилт	Зөрүү
1-р улирал	89,995.5	50,000.0	39,995.5	54,804.4	27,101.4	27,703.0	56,651.7	27,100.0	29,551.7
2-р улирал	258,092.1	280,281.9	-22,189.8	157,297.0	185,000.0	-27,703.0	157,041.7	186,593.2	-29,551.5
3-р улирал	154,902.6	210,000.0	-55,097.4	107,354.0	105,000.0	2,354.0	121,309.8	50,000.0	71,309.8
4-р улирал	107,444.3	70,152.6	37,291.7	37,540.8	39,894.8	-2,354.0	34,019.9	105,329.9	-71,310.0
Нийт дүн	610,434.5	610,434.5	0.0	356,996.2	356,996.2	0.0	369,023.1	369,023.1	0.0

Хүснэгтээс харахад: ОНХС-гаас олгох шилжүүлгийн орлогыг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлээгүйгээс сумдад олгох орлогын шилжүүлгийг мөн батлагдсан төсвийн хуваариас илүү, дутуу санхүүжүүлсэн байна.

Иймд ОНХС-гаас олгох санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олгох зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Бүлэг 2

ОНХС-аар хэрэгжүүлсэн ажлуудын гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагаас тавих хяналт хангалтгүй байна

2.1 ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөж, урьдчилсан саналын жагсаалтыг батлуулсан байна.

Аймаг болон Сүмбэр сум нь ОНХС-гийн хөрөнгийг орон нутгийн бодлого тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөж, урьдчилсан саналын жагсаалтыг баталж, аймаг сумдын төсвийн болон орон нутгийн өмчит байгууллага болон багийн иргэдээс саналыг авч эрэмбэлэн ажилласан байна.

Аймгийн Засаг даргын 2015.08.18-ний өдрийн А/253 тоот захирамжаар 2016 оны аймгийн ОНХС-гийн төсвөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг авч, нэгтгэн боловсруулах, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, иргэдээс санал авах, урьдчилсан саналын жагсаалт гарган нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, гаргасан саналыг ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан эрэмбэлж, аймгийн ИТХ-д хүргүүлж ажилласан байна.

Харин Шивээговь сумын Засаг даргын 2015 оны 05 сарын 12-ны өдрийн А/36 тоот захирамжаар байгуулсан “Төсөл, арга хэмжээг төлөвлөхөд арга зүйн зөвлөгөө өгөх” ажлын хэсэг, Баянтал сумын Засаг даргын даргын 2015 оны 12 сарын 15-ны өдрийн А/65 тоот захирамжаар байгуулсан ажлын хэсэг багийн иргэдээс ирсэн саналыг хүлээн авч тус тус эрэмбэлсэн боловч Орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй хэрхэн уялдуулан төлөвлөх үйл ажиллагаа хангалтгүй байна.

2.2 ОНХС-аас сумдад иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй зарим ажлуудыг ИТХ-ын тогтоолоор баталж, хэрэгжүүлсэн байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг сумдын багийн иргэдийн нийтийн хурлаар нээлттэй хэлэлцүүлэн санал авч эрэмбэлж байгаа хэдий ч сумдын ИТХ-ын тогтоолоор иргэдийн санал аваагүй, эрэмбэлэгдээгүй зарим ажлуудыг баталсан байна. Тухайлбал: Сүмбэр сум 5-р сургуулийн камержуулах ажилд 9,489.7 мянга, Шивээговь сум иргэний танхимд автомашин худалдан авсаны зөрүү 3,000.0 мянга, Шивээговь сумын хүндэтгэлийн хаалга хийх ажилд 29,808.3 мянга, нийт 42,298.0 мянган төгрөгийн ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-д зааснаар “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

Иймд сумдын ИТХ, Засаг даргад дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.3 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын ТЭЗҮ, зураг төсөв нь урьдчилан батлагдсан байна.

Аймаг, сумдын ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг урьдчилан батлуулсан байна. Тухайлбал: аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэс болон сумд нь 2016 оны ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын ТЭЗҮ, зураг төсвийг өмнөх оны ОНХС-гийн төсөвт тусгуулан батлуулж, зураг төсвийг хийлгэсэн байна.

2.4 ОНХС-аар хэрэгжүүлсэн зарим хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг хууль журмын дагуу сонгон шалгаруулаагүй байна.

2016 онд аймаг болон сумдын ОНХС-гаар 83 хөрөнгө, оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаас 77 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 6 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй байна.

Энэ нь аймгийн ИТХ-ын 2016.12.22-ны өдрийн 03 дугаар тогтоолоор төсвийн тодотгол хийж, аймгийн ОНХС-гийн төсөвт 480,174.1 мянган төгрөгийн 5 хөрөнгө оруулалтын ажлыг, мөн Сүмбэр сумын ИТХ-ын 2016.10.03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 2017 онд хэрэгжүүлэх ажлын зураг төсөв боловсруулах 5,000.0 мянган төгрөгийн ажлыг тус тус нэмж тодотгосноос тендер шалгаруулалтыг ондоо багтаан явуулах боломжгүй болж, он дамжсан байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа нээлттэй тендер шалгаруулалтаар 5, харьцуулалтын аргаар 10 хөтөлбөр, төсөл арга хэмжээний ажлыг тус тус шалгаруулж, 15 ажлыг шууд гэрээг байгуулж, гүйцэтгүүлсэн байна.

Сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилт тодотголоор хасагдсан гэсэн шалтгаанаар хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг жижиглэн 10,000.0 мянган төгрөг хүртэлх төсөвтэй 37 ажилд шууд худалдан авалт хийх, 8 ажлыг харьцуулалтын аргаар, 2 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажилласан байна.

2016 онд аймгийн ОНХС-гийн 1, Баянтал сумын ОНХС-гийн 1 нийт 2 ажлын тендер шалгаруулалтад маргаан үүсч Сангийн яаманд хянагдсан байна.

Тендер шалгаруулалттай холбоотой 2 гомдлыг Сангийн яаманд хянуулснаас аймгийн ОНХС-гийн аймгийн төвийн гадна шугам сүлжээний засварын ажлын тендер шалгаруулалтыг хуулийн дагуу үнэн, зөв шалгаруулсан гэсэн дүгнэлт гаргасан байна.

Харин Баянтал сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “152-р байрны гадна тоглоомын талбай байгуулах, тохижилтын ажлын” тендер шалгаруулалтыг хууль зөрчсөн гэж үзээд Сангийн яамнаас холбогдох шийдвэр гаргасан боловч шийдвэр нь он дамжин гарсан байна. Энэ нь Баянтал сумын Засаг даргын тамгын газрын даргын 2016.11.17-ны өдрийн А/34 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны гишүүд тендер шалгаруулалтыг зохион байгуулахдаа хариуцлагагүй хандаж, хууль тогтоомж зөрчин тендерт шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулснаас маргаан үүссэн байна.

Иймд тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй үнэлгээний хорооны гишүүдэд хариуцлага тооцуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Мөн Баянтал сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “4-р сургуулийн дотуур байрны засвар”-ын ажилд харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт явуулсан бөгөөд үнэлгээний хорооны 2016.12.16-ны өдрийн дүгнэлтээр тендерт оролцсон байгууллагууд бүгд шаардлага хангаагүй тул уг тендерийг хүчингүйд тооцож, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 33.4 дэх заалтын дагуу гэрээ байгуулан ажиллах зөвлөмжийг захиалагч буюу Баянтал сумын ЗДТГ-ын дарга Б.Улаанхүүд 2016.12.16-ны өдөр хүргүүлсэн байна.

Гэтэл Захиалагч нь үнэлгээний хорооны дүгнэлт, зөвлөмжийг зөрчин тендерт оролцоод шаардлага хангаагүй “Харвайн толгой” ХХК-иар ажлыг гүйцэтгүүлэхээр 2016.12.26-нд шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 34.2-т "Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхитай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана" гэснийг зөрчсөн байна.

Иймд үнэлгээний хорооны дүгнэлт, зөвлөмжийг зөрчиж шаардлага хангаагүй байгууллагатай гэрээ байгуулсан захиалагчид хариуцлага тооцуулах албан шаардлага өгөхөөр өгөхөөр шийдвэрлэв.

2.5 ОНХС-ийн хөрөнгийг сумын удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

Сүмбэр сумын ОНХС-аас 3-р багийн нутаг дэвсгэрт 2-р байрны гадна дулаалгын /фасад/ ажлыг “Цагаан зуун” ХХК-иар гүйцэтгүүлсэн боловч техникийн тодорхойлолтод заагдсан дээврийн адрын хөндийг дулаалах 31,179.1 мянган төгрөгийн ажлыг дутуу хийсэн байна. Гэтэл мэргэжлийн байгууллагын дүгнэлт гараагүй байхад захиалагч уг ажлыг хийж гүйцэтгэх шаардлагагүй гэж үзээд хууль тогтоомж зөрчин хийгдээгүй ажлын зардлаар Сүмбэр сумын ЗДТГ-ын дээврийн засварын ажлыг тус компаниар хийлгэж урсгал засварын зардлыг санхүүжүүлсэн байна.

Мөн Шивээговь сумын ОНХС-аас иргэний танхимд авто машин худалдан авсны үнийн зөрүү 3,000.0 мянган төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.1-д "Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно", Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан зааврын 4.4-т "Аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх" гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд хууль тогтоомж зөрчин, эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр ОНХС-аас урсгал засварын зардлыг санхүүжүүлсэн тул захиалагчид хариуцлага тооцуулах санал хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээнд зарцуулах төсвийн хувь хэмжээг зааглаагүй, хөтөлбөр, төсөл арга хэмжээний нэршлийг тодорхой тусгаагүйгээс сангийн хөрөнгийг хөтөлбөр, төсөл арга хэмжээ нэрээр зориулалт бусаар зарцуулж, урсгал зардлуудыг санхүүжүүлэх, хөрөнгө бэлтгэх зэргээр тус сангийн үр нөлөөг бууруулж, үр ашиггүй зардал гарах нөхцлийг бүрдүүлж байна. Тухайлбал: аймаг, сумдын ОНХС-гаас хөтөлбөр нэрээр 2016 онд аймгийн Нэгдсэн эмнэлэгт биохими, иммунологийн автомат анализатор худалдан авахад 40,000.0 мянга, Боржигин чуулгад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад 19,930.5 мянга, аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт шаардлагатай тоног төхөөрөмж 4,800.0 мянга, Цагдаагийн хэлтэст тоног төхөөрөмж худалдан авахад 26,202.0 мянга, Хөдөөгийн багуудын тохижилтын ажилд 30,000.0 мянга, нийт 120,932.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.6 ОНХС-аар хэрэгжүүлсэн ажлуудын гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагаас тавих хяналт хангалтгүй байна.

2016 онд аймаг болон сумдын ОНХС-гаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын захиалагчийн хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар хэрэгжүүлэхээр захиалагчтай гэрээ байгуулж ажилласан байна.

ГХБХБГ нь захиалагчтай байгуулсан гэрээндээ хяналтын зардлын тодорхой хувийг захиалагчид олгохоор тусгасан, мөн зарим ажлуудад хяналт тавих гэрээ хийгдээгүй байна. Тухайлбал:

- АЗДТГ-т 8,963.1 мянга, Сүмбэр суманд 1,564.7 мянга, нийт 10,527.8 мянган төгрөгийн хяналтын зардлыг захиалагчид олгосон,
- Шивээговь сум Сумын төвийн авто зам дагуу тарьсан модыг хашаажуулах, хамгаалалт хийх ажилд хяналт тавих гэрээ хийгдээгүйгээс захиалагч өөрөө хяналт тавьж, хяналтын зардлын 710.0 мянган төгрөгийг авсан байна.

Эдгээр нь Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 73 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Барилга захиалагчийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.5.-д “Орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн хот байгуулалт, барилга захиалагчийн албаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх” гэснийг зөрчсөн байна.

Иймд захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах зөвлөмж өгөв..

Аймаг, сумдын 2016 оны ОНХС-ийн зарцуулалтаар аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийг дурдвал:

Аймгийн ОНХС-гийн зарцуулалт:

1. Аймгийн Боржигин чуулгад шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх 19,930.5 мянган төгрөгийн ажлыг “Спийд Аксон” ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч 264.0 мянган төгрөгийн зайны микрофон ажиллахгүй байна. Иймд гэмтэлтэй тоног төхөөрөмжийг гүйцэтгэгч байгууллагаар солиулж, чанарын шаардлага хангасан хөрөнгө нийлүүлэх албан шаардлага өгөв.
2. Сүмбэр сумын 3 дугаар багийн 5-р байрны подвалын засварын ажлыг 60.000.0 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн боловч холбогдох байгууллагад

хариуцуулан хүлээлгэж өгөөгүй, данс бүртгэлд тусгуулаагүй, хариуцах эзэн байхгүйгээс айл өрхүүдийн байрны шугамын гэмтлээс болж подвалд ус алдаж хийсэн засварын ажлыг үр дүнгүй болгосон байна. Түүнчлэн аливаа хөрөнгө оруулалтын ажлыг хийж гүйцэтгэхдээ асуудлыг цогцоор нь шийдвэрлээгүйгээс хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах нөхцөл бий болсон байна. Энэ нь Сангийн сайдын 2014.03.06-ны өдрийн 43-р тушаалаар баталсан ОНХС-гийн зааврын 4 дүгээр зүйлийн 4.9-д “ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон өмчийн урсгал зардлын тооцоо, цаашид төсөвт нөхөн нөлөөлөх болон урсгал зардлыг хэрхэн шийдвэрлэх талаар санал туссан байх” гэснийг зөрчсөн байна. Иймд тус подвалыг холбогдох байгууллагад хүлээлгэн өгч, зориулалтын дагуу ашиглаж, ашиглалтыг сайжруулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Баянтал сумын ОНХС-гийн зарцуулалт:

1. Баянтал сумын уурын зуухны барилгын их засварын ажлыг 2014.12.22-2015.09.01-ний хооронд 628,188.0 мянган төгрөгөөр “Термокалор” ХХК-иар хийх гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан боловч гэрээний хугацааг сунгаж 2016.05.25-нд ашиглалтад хүлээн авсан байна. Гэтэл тус уурын зуухыг ашиглах боломжгүйгээс 2016 онд ОНХС-гаас хуучин уурын зуухыг дахин 40,000.0 мянган төгрөгөөр засварлаж, төсвийн хөрөнгийг үр дүнгүй ажилд зарцуулсан байна. Тус уурын зуухны ажлыг төлөвлөхдөө сумын хүн амын суурьшил, нягтрал, орон сууцны хэрэгцээ, хангамж, хэрэглэгчийн суурь судалгаа, эдийн засгийн нөхцөл байдал, орон сууцны ашиглалтад орох хугацаа зэргийг үндэслэлтэй тооцоолоогүйгээс одоогийн нөхцөл байдалд ашиглахад хүчин чадал хэд дахин өндөр, ашиглалтын зардал их шаардагдах нөхцөл байдал бий болсон нь төсвийн хөрөнгийг ашиглах боломжгүй, үр өгөөжгүй хөрөнгө оруулалтад зарцуулж төсөвт хохирол учруулсан байна. Иймд уг ажлыг хуулийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэлээ.
2. Баянтал сумын уурын зуухны барилгын их засварын зураг төсвийг 2014 онд “ДТУА” ХХК-тай гэрээ байгуулан 10,000.0 мянган төгрөгөөр хийж гүйцэтгүүлсэн байна. Гэтэл 2015 онд тус уурын зуухны барилга угсралт, засвар шинэчлэлтийн ажлыг “Термокалор” ХХК-иар хийж гүйцэтгүүлэхээр 628,188.0 мянган төгрөгийн гэрээ байгуулахдаа гэрээний үнийн дүнд зураг төсвийн үнийг давхардуулан тусгаж, 5,000.0 мянган төгрөгийг олгосон байна. Иймд давхардуулан олгосон зураг, төсвийн үнийг буцаан төлүүлж, орон нутгийн орлого болгохоор төлбөрийн акт тогтоов.
3. Баянтал сум ОНХС-гаас баяр наадмын зардалд 5,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан баяр наадам хийгээгүй байна. Гэтэл зардлыг санд нь буцаан төвлөрүүлээгүй, зориулалт бусаар 2,573.9 мянган төгрөгийг зарцуулсан тул 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар орон нутгийн орлого болгохоор төлбөрийн акт тогтоосон байна.
4. Сумын цэцэрлэгийн дээврийн засварын ажлыг “Их даян бүүвэй” ХХК 38,160.3 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн боловч хүлээлгэн өгсөн ажил нь чанарын шаардлага хангаагүй, дээврийн хар цаас нь ам дарсан бэхэлгээ хийгдээгүйгээс хуурсан тул баталгааны хугацаанд дахин засварлуулахаар холбогдох байгууллагад албан шаардлага өгөв.
5. Баянтал сумын Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх зорилгоор 8,950.0 мянган төгрөгийн өвсийг худалдан авсан боловч өвсийг стандартын дагуу нуруулдаж хураагаагүй, тоолох боломжгүй, эмх замбараагүй, өвсний боодол задарсан

зэрэг нь өвсний хадгалалт, хамгаалалтад тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна. Иймд өвсийг эмх цэгцтэй хурааж, чанарыг алдагдуулахгүй байх, хадгалалтын горим, заавар журмыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв.

6. Баянтал сумын 2-р багийн нутаг дэвсгэрт худаг гаргах ажлын гэрээг “Номгон хайрхан оргил” ХХК-тай 2016.06.09-2016.07.10-ны хооронд хийж гүйцэтгэхээр 19,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, санхүүжилтийн урьдчилгаа 50 хувь болох 9,500.0 мянган төгрөгийг олгосон боловч гэрээний хугацаанд ажил хийгдээгүй байна. Иймд гэрээг цуцалж, хөрөнгийг ОНХС-д буцаан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Сүмбэр сумын ОНХС-гийн зарцуулалт:

1. Сүмбэр сумын ОНХС-аар 5-р сургуулийг камержуулах ажлыг “Женералтеч” ХХК-иар гүйцэтгүүлж, 19 камер нийлүүлсэн боловч 1,045.0 мянган төгрөгийн 3 камерийг суурилуулаагүй, Сүмбэр сумын ЗДТГ-т ашиглуулж байгаа, 1,060.0 мянган төгрөгийн 4 камер ашиглалтын шаардлага хангахгүй, эвдэрч гэмтсэн байна. Иймд 2,105.000 төгрөгийн ашиглалтын шаардлага хангаагүй, эвдэрч гэмтсэн болон дутуу суурилуулсан хөрөнгийг гүйцэтгэгч байгууллагаар засварлуулж, ашиглалтад оруулах албан шаардлага өгөв.
2. Багийн төвүүдийг тохижуулах ажилд 30,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, санхүүжилтийн урьдчилгаа 70 хувь буюу 21,000.0 мянган төгрөгийг олгосон боловч 2 багийн төвийн ажил нь дутуу хийгдсэн, 1 багийн төвийн ажил эхлээгүй бөгөөд хүйтний улирал эхэлсэнтэй холбогдуулан ажлыг зогсоосон, гэрээний сунгалт хийгдээгүй, хугацаа хэтэрсэн зөрчил илэрлээ. Иймд гэрээний хугацаа хэтэрсэн, дутуу хийгдсэн ажлыг чанартай хийж гүйцэтгүүлэн, гэрээний биелэлтийг дүгнэж, ашиглалтад хүлээх авах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.
3. Усан хангамжийг сайжруулах зорилгоор ухаалаг худаг гаргах 9,152.4 мянган төгрөгийн ажлыг “Ус-Ду” ОНӨААТҮГ-аар хийж гүйцэтгүүлсэн боловч худгийн барилга нь дулаалга байхгүйгээс худгийн тоног төхөөрөмжийг өвлийн улиралд ашиглах боломжгүй, хөлдөх эрсдэлтэй, цахилгаанаар хангагдаагүйгээс иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй, ашиглах боломжгүй, үр дүнгүй ажил хийгдсэн байна. Иймд тус худгийг иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эрчим хүчний эх үүсвэрээр хангах, дулаалга хийж ашиглалтад оруулан хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх албан шаардлага өгөв.
4. Сүмбэр сумын ОНХС-аар хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж, жил бүр төсөв батлуулсан боловч хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс нийт 8,888.8 мянган төгрөгийг зарцуулаагүй хэмнэж, он дамжуулсан байна. Иймд хэрэгжих боломжгүй хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв. Энэ нь Сангийн сайдын 43 дугаар тушаалаар баталсан ОНХС-гийн зааврын 5 дугаар зүйлийн 5.11-д “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тухайн онд төлөвлөж, ажлын гүйцэтгэл баталгаажсан боловч санхүүжилт хийгдээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээг дараа жилийн төсөвт тусгаж батлуулна” гэснийг зөрчсөн байна.
5. 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 2014 оны санхүүжилтийн үлдэгдэл 2,143.1 мянга, 2015 оны санхүүжилтийн үлдэгдэл 9,3 мянга, 2016 оны санхүүжилтийн үлдэгдэл 9,520.1 мянга, нийт 11,672.5 мянган төгрөгийн өглөгийг бүртгээгүй байна. Иймд 2017 оны санхүүгийн тайланд нийт 11,672.5 мянган төгрөгийн өглөгийг залруулан бүртгэж, зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгөв.

Шивээговь сумын ОНХС-гийн зарцуулалт:

1. ОНХС-гаас сумын төвийн авто зам дагуу тарьсан модыг хашаажуулах ажлыг 35,536.7 мянган төгрөгөөр “Үлэмж тэмүүлэл” ХХК-иар хийж гүйцэтгүүлсэн боловч мэргэжлийн байгууллагатай захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх ажлын гэрээ байгуулаагүй, захиалагчийн хяналтын зардал 710.0 мянган төгрөгийг хууль эрхийн үндэслэлгүйгээр зориулалт бусаар зарцуулсан тул орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт бичив.
2. Сумын төвийн хүндэтгэлийн хаалга хийх ажлыг 29,808.4 мянган төгрөгөөр “Макс майнд” ХХК-иар гүйцэтгүүлсэн боловч техникийн тодорхойлолтод заагдсан зарим ажлууд /сумын танилцуулга, самбар болон нар салхины эрчим хүчээр ажилладаг гэрэлтүүлэг/ дутуу хийгдсэнээс 2,219.9 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Иймд дутуу хийгдсэн 2,219.9 мянган төгрөгийн ажлыг гүйцэтгэгч байгууллагаар хийж гүйцэтгүүлэн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгөв.
3. ОНХС-аас сумын баяр наадмын зардалд 1,000.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан боловч анхан шатны баримтын бүрдэлгүй тул зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өгөв.
4. Сумын өвсний нөөц бүрдүүлэх зорилгоор худалдан авсан 5,370.0 мянган төгрөгийн өвсийг стандартын дагуу нуруулдаж хураагаагүй, чанар байдлыг алдагдуулсан, хадгалалтын горим зөрчигдсэн, өвсийг тоолох боломжгүй, өвсний боодол задарсан зэрэг өвсний хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил илэрлээ. Иймд өвсийг эмх цэгцтэй хурааж, чанарыг алдагдуулахгүй байх, стандартын дагуу хадгалалтын горим, заавар журмыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв.

Түүнчлэн ОНХС-ийн хөрөнгөөр өмнөх онуудад хийгдсэн, он дамжсан зарим ажлуудыг одоог хүртэл хүлээн аваагүй, гэрээний биелэлтийг дүгнээгүй, тайлан тэнцэлд авлага, өглөг үүсгэсэн байна. Тухайлбал:

- Аймгийн ОНХС-аас 2013 онд хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний төв зогсоол байгуулах ажлын гүйцэтгэгчээр Улаанбаатар хотын “Магнус солус” ХХК шалгарч, 58,070.2 мянган төгрөгийн гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгэсэн байна. Гэрээний дагуу 2013 онд 47,362.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон боловч гэрээний хугацаанд ажлаа хийж гүйцэтгээгүй, хүйтний улирал эхэлсэнтэй холбоотой акт үйлдэн ажлыг зогсоож, 2014.04.10-наас 2014.05.20-ныг хүртэлх хугацаанд ажлыг хийж гүйцэтгэхээр гэрээг сунгасан байна. Гэтэл 2014 онд уг компани ажлаа хийж гүйцэтгээгүй алга болсон тул олгосон санхүүжилт 47,362.8 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар, санхүүжилтийн үлдэгдэл 10,707.4 мянган төгрөгийг өглөгөөр тусгаж одоог хүртэл барагдуулаагүй байна. Иймд холбогдох хууль журмын дагуу тус компанитай байгуулсан гэрээний биелэлтийг тооцож, авлага, өглөгийг барагдуулах зөвлөмж өгөв.
- Баянтал сумын ОНХС-аас 2013 онд “ХБХДТ” ХХК-тай Баянтал сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг 158,000.0 мянган төгрөгөөр, 2013.07.19-2013.11.01-ний өдрийн хооронд хийж гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан 153,680.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон боловч одоог хүртэл ажлыг хүлээн аваагүй, санхүүгийн тайланд дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй байна. Иймд санхүүжилтийг бүрэн олгосон боловч одоог хүртэл ажлыг хүлээн аваагүй, гэрээний биелэлтийг дүгнээгүй, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч

ажиллаагүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан тул төсөвт хохирол учруулсан 153,680.0 мянган төгрөгийн ажлыг хуулийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэлээ.

- Баянтал сумын ОНХС-гаар 2014 онд “Ургах наран чойр” ХХК-р Автозам, төмөр зам огтлолцсон уулзварыг камержуулах ажлыг гүйцэтгүүлсэн боловч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй, тайлан балансдаа бүртгээгүй, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулсан байна Иймд зөрчлийг арилгаж, хөрөнгийг данс бүртгэл тусган, ашиглалтад оруулж, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.
- Сүмбэр сумын ОНХС-аас сумын төв замын дагуу мод тарьж, хашаа барих нийт 93,000.0 мянган төгрөгийн ажлын гүйцэтгэгчээр “Классик Тохижилт” ХХК шалгарч, урьдчилгаа санхүүжилтэд 28,087.4 мянган төгрөгийг олгосон бөгөөд ажлын гүйцэтгэлийг хянах явцад хашаа нь техникийн нөхцлийн дагуу хийгдээгүй тул гэрээг цуцалж, шүүхэд шилжүүлэн, олгосон санхүүжилтийг авлагаар бүртгэсэн, мөн Хонхор хотхоны 1 болон 15-р байрны дундах тогтлоомын талбайг сэргээн засварлах ажлыг дутуу гүйцэтгэж, гэрээний биелэлтийг дүгнээгүй, ажлыг хүлээлгэн өгөөгүйгээс санхүүжилтийн үлдэгдэл 8,921.2 мянган төгрөгийг өглөгөөр бүртгэсэн байна. Иймд авлага, өглөгийг барагдуулах зөвлөмж өгөв.

Дээрх зөрчил, дутагдлууд нь захиалагч ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулахдаа санхүүжилтийн ихэнх хувийг /50-70/ олгохоор гэрээлдэг, чанаргүй хийгдсэн ажлуудыг улсын комисс хүлээн авдаг, ажлын гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналт хангалтгүй, гэрээний биелэлтийг дүгнэдэггүй, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцдоггүй, төсвийн хөрөнгийг ашиглах боломжгүй, үр өгөөжгүй хөрөнгө оруулалтад зарцуулсан зэргээс шалтгаалж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах, 60 дугаар зүйлийн 60.3.6-т “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээг хэрэгжүүлэхийг хориглоно”, Сангийн сайдын 2012 оны 290-р тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журмын 3 дугаар зүйлийн 3.3-т “Захиалагч байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргаа төв байгууллагын батлан гаргасан норм, норматив дүрэм болон тухай ажлын батлагдсан зураг төсөл, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон ажлын төлөвлөгөөг үндэслэн ажил нэг бүрээр нь тулган шалгаж баталгаажуулна” гэснийг тус тус зөрчсөн байна.

2.7 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд бэлтгэсэн зарим хөрөнгийг холбогдох байгууллагуудын данс бүртгэлд бүртгэж, тайлагнаагүй байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж, улсын комисс хүлээн авсан ажлуудыг холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу данс бүртгэлд тусгуулахаар ОНХС-ийн мэргэжилтнүүд жагсаалтыг бэлтгэн аймгийн ИТХ-д хүргүүлсэн байна. Аймгийн ИТХ-ын Орон нутгийн өмч хариуцсан мэргэжилтэн жагсаалтыг хянаж баталгаажуулснаар хөрөнгийг данс бүртгэлд тусгуулах аймгийн

ИТХ-ын тогтоол шийдвэр гарсан боловч хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.Тухайлбал:

- Аймгийн ОНХС-аас 5-р байрны подвалын их засварын 60,000.0 мянган төгрөгийн ажлыг “Бадрах-70” СӨХ-д, 3-р байрны подвалын шугам сүлжээг шинэчлэх засварын 60,000.0 мянган төгрөгийн ажлыг “Ус-Ду” ОНӨҮГ-т тус тус бүртгүүлэхээр шийдвэр гарсан боловч хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй,
- Орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн их засварын ажлыг АЗДТГ-ын данс бүртгэлд 3,570.0 мянган төгрөгөөр дутуу тусгасан,
- Нэгдсэн эмнэлэгт генераторын барилга, үүдний хаалга, цахим хүлээлгийн танхимын ширээ сандал, үйлчлүүлэгчийн хүлээлгийн сандал зэрэг нийт 9,768.0 мянган төгрөгийн хөрөнгийг нэр төрлөөр нь хүлээлгэн өгсөн боловч байгууллагын данс бүртгэлд бөөн дүнгээр генераторын барилга гэсэн нэрээр бүртгэсэн,
- Сүмбэр сумын ОНХС-гаас хийгдсэн шинээр өмчлөлд олгогдсон газруудад цахилгаан татах 50,755.5 мянган төгрөгийн ажлыг “Цахилгаан түгээх сүлжээ” компанид, 1-р байрны подвалын шугам, сүлжээг шинэчлэх 60,000.0 мянган төгрөгийн ажлыг “Ус-Ду” ОНӨҮГ-т , мал хамгаалах хөтөлбөрийн хүрээнд хүн ам, малын жилийн эцсийн тооллого хийхтэй холбогдуулан худалдан авсан 349.9 мянган төгрөгийн принтер болон хөдөөгийн багийн төвүүдийн тохижилтын ажлын урьдчилгаа 21,000.0 мянган төгрөгийг дуусаагүй барилгаар бүртгээгүй,
- Аймгийн Цагдаагийн хэлтэст нийлүүлсэн 26,202.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн үнийн дүнг 3,252.0 мянган төгрөгөөр дутуу тусгасан,
- Шивээговь сумын ОНХС-гаас хийгдсэн 7 хөрөнгө оруулалтын 116,780.1 мянган төгрөгийн ажлыг Сумын ЗДТГ нь хөрөнгөөр бүртгээгүй,
- Баянтал сумын ОНХС-гаас хийгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн нэгтгэн гаргаж, 4-р цэцэрлэгийн дээврийн засварын ажлыг 633.8 мянган төгрөгөөр илүү, “Талын илч” ОНӨҮГ-ын уурын зуухны засварын ажлыг 400.0 мянган төгрөгөөр дутуу тооцож, аймгийн ИТХ-д хүргүүлсэнээс үнийн дүн зөрүүтэй бүртгэгдсэн,

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал тусгана,” Сангийн сайдын 43 дугаар тушаалаар баталсан ОНХС-гийн зааврын 8 дугаар зүйлийн 8.6-д “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд хөрөнгийн бүртгэлийг нэр, төрлөөр болон дансны ангиллаар үнэн, зөв бүртгэх талаар холбогдох байгууллагуудад албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Бүлэг 3

ОНХС-ийн зарцуулалтад тавих шат шатны хяналт хангалтгүй байгаагаас хэрэгжилтийг тайлагнаагүй байна.

3.1 ИТХ-ын дэргэдэх хяналтын хороог байгуулаагүй, аймгийн Дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавих хяналтын хороог байгуулж ажиллаагүй байна.

Мөн аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс ОНХС-гийн 2016 оны зарцуулалтад хяналт шалгалт хийгээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 43 дугаар тушаалаар баталсан ОНХС-гийн зааврын 9 дүгээр зүйлийн 9.1-д “ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгуулагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана”, 9.2-д “ОНХС-гаас оруулж байгаа хөрөнгө оруулалт, хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээнд гүйцэтгэлийн, санхүүгийн хяналт шалгалтыг дотоод аудитын алба хэрэгжүүлнэ” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороог, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан томилж ажиллуулах, ОНХС-ийн зарцуулалтад жил бүр дотоод хяналт шалгалт хийж байх талаар зөвлөмж өгөв.

Харин аймгийн Засаг даргын 2016.10.12-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу Сүмбэр, Шивээговь, Баянтал сумын орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хэрэгжилтийг шалгах, бодлогын удирдлагаар хангах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, сумдын худалдан авах ажиллагааны явц, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, төлөвлөлттэй танилцаж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт, зааварчилгаа, зөвлөмж өгөх зорилгоор хяналт шалгалт хийж, сумдын хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны тайланг үнэлсэн байна.

Тайлангийн үнэлгээгээр Сүмбэр сум 70, Баянтал сум 46, Шивээговь сум 64 оноо тус тус авсан бөгөөд сумдын бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны талаарх сургалт зохион байгуулж, зөвлөмж өгсөн байна.

3.2 ОНХС-гийн хэрэгжилтийн тайланг аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлээгүй байна.

2016 онд сумдын хөрөнгө оруулалт хариуцсан орон тооны мэргэжилтнүүд тогтвор суурьшилтай ажиллаагүй, солигдсоноос ОНХС-гийн хэрэгжилтийн тайланг аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлээгүй байна.

Сумдууд тайлангаа аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлээгүйгээс аймаг болон сумдын ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар тухай бүр томилоогүй байна.

Энэ нь Сангийн сайдын 43 дугаар тушаалаар баталсан ОНХС-гийн зааврын 10 дугаар зүйлийн 10.1-д “Сумдын ОНХС-гийн хэрэгжилтийн явцын хагас жилийн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 10-ны дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлнэ”, ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар тухай бүр томилж ажиллуулна” гэснийг зөрчсөн байна.

Иймд Сангийн сайдын тушаалаар баталсан зааврыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.3 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн мэдээллийг зааврын дагуу ил тод мэдээлсэн байна.

2016 онд аймаг болон сумдууд ОНХС-гийн мэдээллийг аймгийн болон сумын цахим хуудас, Сангийн яамны ОНХС цэс, www.pmmis.mof.gov.mn, www.meps.gov.mn, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулж ажилласан байна.

3.4 Орон нутгийн хөгжлийн сангийн зааврыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

ОНХС-гийн зааврыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулан баталсан хэдий ч дараах асуудлуудыг тусгаж өгөх шаардлагатай байна. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний санхүүжилтийн урьдчилгааг ямар хувь харьцаагаар олгохыг тодорхой тусгаагүйгээс захиалагч зөвхөн гэрээгээр зохицуулж байгаа нь эрсдэлтэй байна. Өөрөөр хэлбэл захиалагч гэрээнд санхүүжилтийн ихэнх буюу 50-70 хувиар олгохоор тусгаж байгаа нь гүйцэтгэгч компанийг санхүүгээр дэмжээд зогсохгүй, ихэнх санхүүжилтээ авсан байгууллага ажлаа чанаргүй хийж гүйцэтгэдэг, хугацаанд нь хүлээлгэн өгдөггүй, хугацаа хэтрүүлдэг, санхүүжилтийг эргэлтэнд оруулж бизнесийн зорилгоор ашиглах нөхцөл бүрдэж байна.
2. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээнд зарцуулах төсвийн хувь хэмжээг зааглаагүй, хөтөлбөр, төсөл арга хэмжээний нэршлийг тодорхой тусгаагүйгээс сангийн хөрөнгийг хөтөлбөр, төсөл арга хэмжээ нэрээр зориулалт бусаар зарцуулж, урсгал зардлуудыг санхүүжүүлэх, хөрөнгө бэлтгэх зэргээр тус сангийн үр нөлөөг бууруулж, үр ашиггүй зардал гарах нөхцлийг бүрдүүлж байна.

Иймд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын санхүүжилтийг хэрхэн олгох талаар зохицуулсан заалт оруулах, хөтөлбөр, төсөл арга хэмжээний нэршил, зарцуулах хөрөнгийн хэмжээг тодорхой болгох шаардлагатай байна.

3.5 Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 40 хувьтай байна.

Өмнөх онд хийгдсэн Нийцлийн аудитаар нийт 1,060,618.7 мянган төгрөгийн зөрчил дутагдал илрүүлсэн бөгөөд 651.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 540,989.8 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэнийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Өмнөх оны аудитаар нийт 10 зөвлөмж өгсөн боловч 4 зөвлөмжийг хэрэгжүүлж, 6 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, зөрчлийг давтан гаргаж зөвлөмжийн хэрэгжилт 40 хувьтай байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийсэн Нийцлийн аудитаар нийт 1,898.676.4 мянган төгрөгийн зөрчил дутагдал илрүүлсэн бөгөөд 15,210.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 536,218.5 мянган төгрөгийн албан шаардлага, 330,052.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулах зөвлөмж өгч, 235,327.9 мянган төгрөгийн зөрчил гаргасан холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлэхээр, 791.868.0 мянган төгрөгийн зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлэхээр тус тус шийдвэрлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон аймгийн ОНХС-гаас олгох шилжүүлгийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу санхүүжүүлээгүй байна.
2. Сүмбэр сум ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл 2,892.6 мянган төгрөгийг ОНХС-гийн орлогын төлөвлөгөөнд оруулж батлуулаагүй байна.
3. Сүмбэр, Шивээговь сумууд иргэдийн санал авч эрэмблэгдээгүй зарим ажлуудыг ИТХ-ыногтоолоор баталж, хэрэгжүүлсэн байна.
4. Сумдад иргэдээс ирсэн саналыг хүлээн авч эрэмбэлсэн боловч Орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэйгээ уялдуулан төлөвлөх үйл ажиллагаа хангалтгүй байна.
5. Захиалагч болон үнэлгээний хорооны гишүүд хууль тогтоомж зөрчиж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.
6. Захиалагчийн хяналтын зардлыг бүрэн олгоогүйгээс ОНХС-аар хэрэгжүүлсэн ажлуудын гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагаас тавих хяналт хангалтгүй, чанаргүй, дутуу хийгдсэн ажлуудыг хүлээн авсан байна.
7. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж, улсын комисс хүлээн авсан ажлуудыг холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу данс бүртгэлд тусгуулахаар аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэр гарсан боловч хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.
8. ОНХС-ийн хөрөнгөөр өмнөх онуудад хийгдсэн, он дамжсан зарим ажлуудыг одоог хүртэл хүлээн аваагүй, гэрээний биелэлтийг дүгнээгүй, тайлан тэнцэлд авлага, өглөг үүсгэсэн байна.
9. ОНХС-ийн зарцуулалтад тавих шат шатны хяналт хангалтгүй байгаагаас хэрэгжилтийг тайлагнаагүй байна.
10. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 40 хувьтай, зөрчлийг давтан гаргасан нь захиалагч ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулахдаа санхүүжилтийн ихэнх хувийг /50-70/ олгохоор гэрээлдэг, чанаргүй хийгдсэн ажлуудыг улсын комисс хүлээн авдаг, ажлын гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналт хангалтгүй, гэрээний биелэлтийг дүгнэдэггүй, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцдоггүй зэргээс шалтгаалж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Аймаг, сумдын ИТХ-ын даргад:

1. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан ОНХС-гийн зааврын 9.1 дэх заалтыг хэрэгжүүлэн ажиллах
2. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг данс бүртгэлд тусгуулахаар гаргасан ИТХ-ын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангуулах, хяналт тавих
3. ОНХС-ийн хөрөнгөөр орон нутгийн иргэдийн санал аваагүй, эрэмбэлэгдээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг ИТХТХ-аар батлахгүй байх

Аймгийн Засаг даргад:

1. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан ОНХС-гийн зааврын 9.2-д заасны дагуу аймгийн Дотоод аудитын албанаас /Хяналт үнэлгээ, шинжилгээ дотоод аудит/ ОНХС-гийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд бэлтгэсэн хөрөнгийг холбогдох байгууллагуудын данс бүртгэлд бүрэн тусгуулах

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргад:

1. Сумдын ОНХС-ийн төлөвлөлт нь орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтэйгээ уялдаж байгаа эсэхэд хяналт тавьж, арга зүйгээр хангах
2. Захиалагч байгууллагын хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах
3. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлуудын чанар, стандартад анхаарч, дутуу, чанаргүй гүйцэтгэсэн ажлуудыг хүлээж авахгүй байх, гэрээний биелэлтийг дүгнэж, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлдэг байх
4. ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг ОНХС-ийн зааврын дагуу тайлагнаж хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлж байх.
5. ОНХС-гийн өмнөх оны дутуу ажлуудыг хүлээн авч авлага, өглөгийг барагдуулж ажиллах
6. Аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, тус аудитаар илэрсэн алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

Сумдын Засаг дарга нарт

1. ОНХС-аар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэйгээ уялдуулан төлөвлөж, хэрэгцээ шаардлагад нийцсэн үр дүнтэй ажлуудад зарцуулах
2. Захиалагч байгууллагын хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, хяналтын зардлыг зориулалт бусаар зарцуулахгүй байх,
3. Дутуу буюу чанаргүй гүйцэтгэсэн ажлуудыг хүлээж авахгүй байх, гүйцэтгэгч байгууллагаар гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулах

4. Гүйцэтгэгчтэй байгуулах гэрээний урьдчилгаа санхүүжилтийг учирч болох эрсдэлийг тооцож, оновчтой хуваарилж санхүүжүүлэх
5. ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг ОНХС-ийн зааврын дагуу тайлагнаж хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлэх
6. ОНХС-гаас хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл, арга хэмжээг он дамжуулж хэрэгжүүлэхгүй байх
7. ОНХС-гийн өмнөх оны дутуу ажлуудыг хүлээн авч авлага, өглөгийг барагдуулж ажиллах, санхүүгийн тайланд авлага, өглөгийг үнэн зөв бүртгэх
8. ОНХС-ийн хөрөнгийг хөтөлбөр, төсөл арга хэмжээ нэрээр хэт жижиглэн, зориулалт бусаар буюу урсгал үйл ажиллагаанд зарцуулж, үр ашиггүй зарцуулалт гаргахгүй байх
9. ОНХС-гийн хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг холбогдох байгууллагын данс бүртгэлд үнэн зөв тусгуулж, ашиглалтыг сайжруулах
10. Аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, тус аудитаар илэрсэн алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газарт уламжлах санал:

1. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн зааврыг боловсронгуй болгох.
2. ОНХС-гийн журамд дараах асуудлуудын талаар тодорхой тусгаж өгөх. Үүнд:
 - Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийтийг хамарсан нэг удаагийн шинжтэй баяр ёслол, тэмдэглэлт өдөр, шагнал урамшуулалд зарцуулахгүй байх тухай заалт бүрхэг,
 - ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажил болон хөтөлбөр, төсөл арга хэмжээнд хувь харьцаа тодорхой бус, санхүүжилтийн урьдчилгаа олгох хэмжээ нь тодорхойгүй,
 - ОНХС-гийн хөрөнгөөр аймагт үйл ажиллагаа явуулж буй улсын төсвийн байгууллагуудад хөрөнгө бэлтгэж өгөх зөв эсэх нь тодорхойгүй байна. Иймд эдгээр асуудлыг журмаар тодорхой зохицуулж өгөх шаардлагатай байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
42017 Чойр, Говьсүмбэр аймаг,
Утас: (01-542) 2-31-18, E-mail: GSAimag@yahoo.com

2017.04.25 № 07/447
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2016 оны зарцуулалтад хийсэн Нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тус төсөлд захиалагчийн хяналтын зардлыг бүрэн олгоогүйгээс Орон нутгийн хөгжил сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлуудын гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагаас тавих хяналт хангалтгүй байгаа талаар туссан байна.

Захиалагчийн хяналтыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраар гэрээгээр гүйцэтгүүлж байгаа боловч захиалагчийн зүгээс зайлшгүй давхар хяналт тавих шаардлага гардаг.

Мөн хийгдэж байгаа ажлуудад техникийн нөхцөл холбогдох байгууллагуудаас авахад зардлын асуудал үүсдэг зэргийг харгалзан үзэхийг хүсэж байна.

Тайлангийн төсөлтэй холбоотой бусад асуудлыг хүлээн зөвшөөрч байгааг үүгээр илэрхийлж байна.


ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Т.БАТ-ЭРДЭНЭ

У. Батсайхан
Уайланг сангийн
архив
2017.04.25

03 0807



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
СҮМБЭР СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

42017 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Чойр,
Утас: 7054 3249

2017.04.14 № 8/210
Тамгай 2017.04.10-ны № 59 -Т

АЙГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн
2016 оны Зарцуулалтанд хийсэн нийцлийн аудитаар
илэрсэн зөрчилтэй танилцаж холбогдох санал
тайлбарыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 2 хуудастай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ХАТАНТӨМӨР



E:\ajil\bichig\A5\toot.2017.doc



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА

42030 Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, Саяхүүл,
Утас: 7054 6204

2017-04-24 № 2/233

танай _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитаар илэрсэн төлбөр, зөрчилтэй холбоотой саналыг хүргүүлэв.

Хавсралт 1 хуудастай



ОРЛОГЧ ДАРГА *[Signature]* ЖЦЭВЭЭНДУЛАМ

D:\2017 oni barimt
05 276




ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНГАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА

42030 Луу, Говьсүмбэр аймаг, Утас: 9306 1817

Ажл. Д. А. № 153
Тайлбар: Ажл. Д. А. -ны № 53 -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд "ОНХС-гийн хөрөнгийн 2016 оны зарцуулалтад хийсэн Нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэлтэй танилцан санал нийлж байгаа тул холбогдох санал байхгүй болно.

ДАРГА  Д.МӨНХ-ЭРДЭНЭ



07 0068

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ХИЙСЭН ТАЙЛБАР

Холбогдох байгууллагуудаас ирүүлсэн тайлангийн төсөлд өгсөн саналтай танилцаад тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.